



11
СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА
Д. БАДАРСАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2015-12-30 № 843
танай _____ -ны № _____ -т

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар
илэрсэн зөрчлийн тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу 2015 оны 9 дүгээр сарын 8-наас 11 дүгээр сарын 06-ныг хүртэлх хугацаанд Сүхбаатар дүүргийн орон нутгийн төсвийн санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэгддэг төсөвт байгууллага, сан, зардлуудын 2015 оны эхний хагас жилийн болон III улирлын байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийлээ.

Аудитыг санхүүгийн аудитын III албаны менежер А.Цогбаяр хянан удирдаж, санхүүгийн аудитын VI багийн ахлах аудитор Х.Оюунчимэг, аудитор Ё.Лхагвадулам, Ж.Мөнхтуяа, шинжээч Ч.Түвшинсайхан нар гүйцэтгэлээ.

Аудитад дүүргийн Засаг Даргын Тамгын газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Орон нутгийн хөгжлийн сан, Хөрөнгө оруулалт, Худалдан авах ажиллагааны алба, Хүүхэд хөгжлийн төв, Ахмадын хороо, Биеийн тамир, спортын хороо, Дотоод аудитын алба, 3, 5, 9, 11, 13, 14, 16, 17, 18, 20 дугаар хороо, Өрхийн эрүүл мэндийн төвүүд (Дотны туслагч БГБХН, Мандам БГБХН, Тэгш саруул БГБХН, Өөдрөг энх БГБХН, Сайн наран БГБХН, Энх сүндэр БГБХН, Түвшин хүч БГБХН, Тэгш мэнд БГБХН, Ачит гар БГБХН, Манай эмч БГБХН, Гэрэлт манал БГБХН, Энэр ази БГБХН, Конвер БГБХН, Энхийн санаа БГБХН, Увидаст од БГБХН гм), Боловсролын байгууллагууд (1, 2, 14, 16, 25, 36, 40, 51, 54, 68, 69, 75, 109, 130, 135, 143, 149, 150, 159, 160, 166, 171, 175, 186, 205, 216, 217 дугаар цэцэрлэг, Монгол Оросын хамтарсан 3 дугаар сургууль, Ажилчин залуучуудын ээлжийн сургууль, Насан туршийн боловсролын төв сургууль, Мэргэжлийн сургалттай биеийн тамир спортын дунд сургууль, 1, 2, 3, 4, 6, 16, 25, 29, 31, 35, 45, 58, 71, 116, 131 дүгээр сургууль) зэрэг нийт 82 байгууллагын 2015 оны эхний хагас жилийн болон III улирлын санхүүгийн тайлангууд болон хөрөнгийн үлдэгдэлд газар дээр нь биет тест хэрэгжүүлэх, тендерийн баримт бичгийн иж бүрдэлийг шалгах, үндсэн хөрөнгө, бараа материалд үлдэгдэлд

1117400843

хэсэгчилсэн хяналтын тооллого хийх, хөрөнгийг данс бүртгэлд үнэн зөв бүртгэсэн эсэхийг тулган баталгаажуулах зэрэг горимуудыг хэрэгжүүллээ.

Завсрын аудитаар дүүргийн хэмжээгээр нийт 10 байгууллага эхний хагас жилийн тооллого хийгээгүй, 29 байгууллага эд хөрөнгийг бүрэн коджуулаагүй, 320 нэр төрлийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, 11 байгууллага эцэг, эхээс хандив тусламжаар өгсөн хөрөнгийг бүртгээгүйгээс гадна 294.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнийг аудитын явцад залруулахаар зөвлөмжийг холбогдох байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарт өглөө.

Дээрх зөрчлүүдийг ангилбал нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 179.8 сая, хууль, тогтоомж, заавар журам зөрчсөн 114.9 сая төгрөгийн зөрчил тус тус илэрлээ. /хавсралт №1, 2/

Иймд аудитаар илэрсэн зөрчилтэй асуудлуудад анхаарлаа хандуулж цаашид давтан гаргахгүй байх арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэн завсрын аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг байгууллага тус бүрээр нь хүргүүлж байна.

ДЭД ДАРГА



Т.САРАНТУЯА

Х.Бопоршааг
Зоринийт
арин дүүрэг
отомин аге
2015.01.11/05